

“МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО” ХК-ИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛЫН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү “Монголын цахилгаан холбоо” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь Компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийн төрөл, хэлбэр, мэдээллийг компанийн хувьцаа эзэмшигч, олон нийтэд тайлагнах, хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү Журам нь Монгол Улсын хууль тогтоомж, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4-р хавсралтаарх Үнэт цаас гаргагчийн хугацаат тайлагнал болон тухай бүр мэдээлэх мэдээллийн агуулга, хэлбэр, Монголын хөрөнгийн биржээс баталсан “Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам”, Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам болох компанийн бодлогын баримт бичиг, дотоод дүрэм, журам, зааварт нийцсэн байна.

1.3. Энэхүү Журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

1.3.1. “**мэдээллийг нээлттэй болгох**” гэж хууль тогтоомж, “Компанийн засаглалын кодекс” болон энэ журамд заасан мэдээллийг компанийн цахим хуудас, эсхүл олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр холбогдох этгээдэд саадгүй хүргэх боломжийг хангасан бусад хэлбэрээр дамжуулан хүргэхийг;


1.3.2. “**хугацаат тайлагнал**” гэж хувьцаа эзэмшигчдийн хурал болон хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх зорилгоор компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг бүрэн агуулсан, тодорхой хугацаанд тайлагнах мэдээллийг;

1.3.3. “**тухай бүр мэдээлэх мэдээлэл**” гэж хувьцаа эзэмшигч болон хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргалтад нөлөө үзүүлэхүйц компанийн бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагаанд бий болсон нөхцөл байдалтай холбоотой мэдээллийг;

1.3.4. “**дотоод мэдээлэл эзэмшигч**” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт тус тус заасан этгээдийг.

ХОЁР. ХУГАЦААТ ТАЙЛАГНАЛЫН МЭДЭЭЛЭЛ

2.1. Хугацаат тайлагналд компанийн хагас жил, жилийн эцсийн үйл



ажиллагааны болон санхүүгийн тайлан хамаарна.

2.2. Компани нь жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг дараа сарын 20-ны өдрийн дотор хороо болон биржид хүргүүлж, биржийн болон өөрийн цахим хуудаст нийтэлнэ.

2.3. Компани нь хугацаат тайланг олон нийтэд хүргэхдээ Компанийн өнгө төрхөд нийцүүлэн, олон нийтэд ойлгомжтой, хялбарчилсан байдал/сэтгүүл, ном, танилцуулга гэх мэт/-аар гаргаж болно.

2.4. Хугацаат тайлагналын мэдээллийг бүрдүүлж хувьцаа эзэмшигч, олон нийтэд мэдээлэх ажлыг компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хэрэгжүүлж зохион байгуулах ба Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хороо мэдээллийг үнэн зөв, бүрэн, цаг хугацаандаа хүргэж байгаад хяналт тавина.

2.5. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд “Компанийн засаглалын кодекс”-т заасан мэдээллийг заавал тусгасан байна.

ГУРАВ. КОМПАНИЙН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ ХУГАЦААТ МЭДЭЭЛЭЛ

3.1. Компанийн хугацаат тайлагнал нь жил, хагас жилийн үйл ажиллагааны тайлан хэлбэртэй байна. Компанийн үйл ажиллагааны тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор, хагас жилийн тайланг дараа сарын 20-ны өдрийн дотор Биржид хүргүүлнэ.

3.2. Компанийн санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв гаргаж жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 02 дугаар сарын 10-ны дотор, хагас жилийн санхүүгийн тайланг дараа сарын 20-ны дотор Биржид хүргүүлнэ.

3.3. Хорооноос зөвшөөрөгдсөн аудитын байгууллагаар баталгаажуулсан аудитлагдсан тайланг Компани нь тайлант жил дууссанаас хойш 04 дүгээр сарын 01-ний дотор Биржийн цахим хуудаст байршуулж олон нийтэд мэдээлнэ.

3.4. Компани нь СЗХ-оос баталсан компанийн засаглалын кодексийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах, тус Кодекст заасан бодлого, журмыг батлан мөрдөх, хэрэгжилтийг тайлагнана. Үүнд:

3.4.1. Компани нь засаглалын кодекст заасан засаглалын зарчмуудын хэрэгжилтийг жилд нэгээс доошгүй удаа “засаглалын тайлан” хэлбэрээр тайлагнах бөгөөд тайланг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон компанийн цахим хуудсанд байршуулж, өөрчлөлт гарсан тухай бүр шинэчлэнэ.

3.4.2. Компани нь компанийн засаглалын зарчмуудын хэрэгжилтийг тайлагнахдаа Кодекст дурдсан зарчмуудыг хэрэгжүүлсэн эсэх, хэрэгжүүлээгүй бол яагаад хэрэгжүүлээгүй, түүнийг орлох бүтэц, биелүүлэх зорилт тавьсан бол хэрэгжүүлэх хугацааг тайлбарлах үүрэгтэй.

3.4.3. Компани нь Кодексийн тайландаа үнэлгээ хийж ирүүлнэ.

3.5. компани нь сайн дурын үндсэн дээр байгаль орчин, нийгэм, засаглал /цаашид БОНЗ гэх/-ын чиглэлээр тайланг хугацаанд авч хэрэгжүүлсэн арга



хэмжээ, үйл ажиллагааны мэдээллийг “Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх журам”-ын хавсралт 1-ийн дагуу гаргаж, жилийн үйл ажиллагааны тайлангийн хамт жилд 1 удаа ирүүлж болно. БОНЗ-ын тайланд дараах асуудлуудыг тайлагнана. Үүнд;

3.5.1. Тогтвортой хөгжлийн менежмент системтэй холбоотой үзүүлэлтүүд гэдэгт тогтвортой хөгжлийн бодлого, бүтэц, удирдлага, тайлагнал болон гишүүнчлэлтэй холбоотой асуудлууд;

3.5.2. Байгаль орчны үзүүлэлтүүд гэдэгт эрчим хүч, хүлэмжийн хий, уур амьсгалийн өөрчлөлт, ус, хог хаягдал, биологийн төрөл зүйл зэрэг асуудлууд;

3.5.3. Нийгмийн үзүүлэлтүүд гэдэгт хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, жендэрийн эрх тэгш байдал, хүртээмж, олон нийтийн харилцаа, худалдан авалтын бодлого зэрэг асуудлууд;

3.5.4. Засаглалын үзүүлэлтүүд гэдэгт авилга, хээл хахууль, засаглал, комплайнс, оролцогч талуудын хамтын ажиллагаа зэрэг асуудлууд;

3.5.5. Салбарын үзүүлэлтүүд гэдэгт банк санхүү, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэр, барилга, уул уурхай, зэрэг салбарт үйл ажиллагаа явуулж буй Компанид тусгайлан хамаарах асуудлууд;

3.6. Хэрэв БОНЗ-ын үйл ажиллагааны тайлангийн маягтад заасан аливаа мэдээллийг Компаниас цуглуулах, танилцуулах боломжгүй бол энэ талаарх шалтгаан болон мэдээллийг цаашид ил тод болгох талаар авч буй арга хэмжээний талаар тайлбар ирүүлнэ.

ДӨРӨВ. КОМПАНИЙН ТУХАЙ БҮР МЭДЭЭЛЭХ МЭДЭЭЛЭЛ

4.1. Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага нь Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдад компанийн бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, түүний эдийн засгийн үзүүлэлт, өмч хөрөнгийн болон удирдан зохион байгуулалтын бүтэцтэй холбоотой өөрчлөлт орсон мэдээллийг тухайн өдрөөс хойш ажлын 1 хоногт багтаан Биржид хүргүүлж, нийтэд мэдээлэх үүрэгтэй.

4.2. Тухай бүр мэдээлэх мэдээллийг “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр хавсралтын маягт 3-ын дагуу ирүүлнэ.

4.3. Компани нь нийтэд хүргэх дээрх мэдээллээс гадна дараах мэдээллийг Биржид хүргүүлнэ. Үүнд;

4.3.1. Гүйцэтгэх удирдлага, ТУЗ-өөс гаргасан үнэт цаасны ханшид болон компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх шийдвэрүүд

4.3.2. Нийт ажиллагсдын 15 болон түүнээс дээш хувьд өөрчлөлт орох буюу чөлөөлөгдөх, шилжих, шинээр ажилд орсон талаарх мэдээлэл;

4.3.3. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч түүний холбогдох этгээд, тэдгээрийн хувьцаа эзэмшилд гарсан өөрчлөлт;

4.3.4. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон тэдгээрийн бусад компанид эзэмшиж байгаа хувьцаанд гарсан өөрчлөлтийн талаарх мэдээлэл;



4.3.5. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 77-р зүйлд заасан дотоод мэдээлэл эзэмшигч, түүнд орсон өөрчлөлт;

4.3.6. Эрхэлж буй үйл ажиллагааны салбарт эзлэх байр суурийн талаарх мэдээлэл, түүнд орсон өөрчлөлт;

4.3.7. Охин, хараат компаниудын үйл ажиллагаатай холбоотой аливаа тусгай зөвшөөрөл эзэмших болсон эсхүл түүний хүчингүй болгосон, барьцаалсан, аливаа хэлбэрээр бусдад шилжүүлсэн тухай мэдээлэл;

4.3.8. Компанийн борлуулалтын орлогын 20 ба түүнээс дээш хувьд нөлөөлөх үйл ажиллагаатай холбогдох аливаа тусгай зөвшөөрөл, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай байгуулсан гэрээ хэлцлийг цуцлах, дуусгавар болгосон талаарх мэдээлэл;

4.3.9. Өөрийн үнэт цаасаа эргүүлэн худалдан авах, худалдан авсан хувьцаагаа бусдад шилжүүлэх, эргэлтэнд гаргах тухай шийдвэрийг ирүүлнэ. Шийдвэрт үнэт цаасыг худалдан авах зорилго, авах хувьцааны тоо, үнэ, нийт хувьцаанд эзлэх хувь, төлбөр хийх хугацааны талаар тусгана.

4.3.10. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдсэн тохиолдолд тухайн мэдээллийг ирүүлэх;

4.3.11. Дараа жилийн үйл ажиллагааны зорилт, төлөвлөгөө, төсвийн талаарх мэдээлэл;

4.3.12. Хууль, журамд заасан бусад холбогдох мэдээлэл;

4.3.13. Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх журмын 8.3.1, 8.3.3-8.3.6, 8.3.9-8.3.12-т тус тус заасан мэдээллийг биржийн болон өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд тухай бүр мэдээлж ажиллана.

ТАВ. ШИНЭЭР БОЛОН НЭМЖ ҮНЭТ ЦААС ГАРГАХАД КОМПАНИАС БИРЖИД ХҮРГҮҮЛЭХ МЭДЭЭЛЭЛ


5.1. Олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрнгөөр санхүүжүүлэх төслийг бүрэн хэрэгжүүлэх хүртэлх хугацаанд татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт, төслийн гүйцэтгэлийн тайланг улирал тутамд гаргаж, дараа сарын 15-ны дотор Биржид хүргүүлнэ.

5.2. Өрийн хэрэгсэл гаргасан бол Хорооны “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын 8-д заасан мэдээллийг Биржид хүргүүлнэ.

5.3. Шинээр болон нэмж үнэт цаас гаргахдаа төслийн явцтай газар дээр очиж хяналт, шалгалтыг Гүйцэтгэх захирлын удирдамжийн дагуу хийж болно.

ГУРАВ. ТУХАЙ БҮР МЭДЭЭЛЭХ МЭДЭЭЛЭЛ

6.1. Тухай бүр нийтэд нээлттэй болгох мэдээлэлд дор дурдсан нөхцөл байдал, өөрчлөлтийн талаарх мэдээллийг тооцох ба тухайн нөхцөл байдал үүссэнээс хойш Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 56.1-д заасан хугацаанд мэдээллийг нээлттэй болгоно.



6.2. Компанийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, бизнест шууд нөлөө үзүүлэхүйц гэрээ, хэлцэл байгуулах, нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, дуусгавар болгох, татгалзах, гэрээний хугацаа дууссантай холбоотой мэдээллийг олон нийтэд мэдээлэх бөгөөд мэдээлэлд гэрээг байгуулсан огноо, гэрээний нөхцөл, гэрээнд оролцогч талуудын эрх үүрэг, гэрээний нэг талд түүний охин хараат компани оролцсон эсэх талаарх мэдээлэл;

6.3. Шүүх, прокурор, төрийн эрх бүхий байгууллагаас үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан, түүний хараат, охин компанийг хариуцагчаар татаж, захиргааны болон эрүүгийн хэрэг үүсгэсэн, шүүхээс дампуурлын тухай хууль тогтоомжийн дагуу эрх хүлээн авагч томилогдсон талаарх мэдээлэл;

6.4. Компанийн нийт активын 25 хувь ба түүнээс дээш хэмжээтэй тэнцэх үл хөдлөх хөрөнгийг бусдад шилжүүлэх, барьцаалсан эсхүл бусад компанийн хяналтын багц худалдан авсан талаарх мэдээлэл, холбогдох гэрээ, хэлцэл;


6.5. Компанийн санхүүгийн байдлын гадуурх бүртгэлтэй холбоотой санхүүгийн болон санхүүгийн бус эрх үүрэг бий болгосон гэрээ, хэлцэл, гүйлгээтэй холбоотой мэдээллийг мэдээлэх бөгөөд мэдээлэлд гэрээ, хэлцлийн хугацаа, үнийн дүн, төлбөрийн нөхцөл, гүйлгээний товч утга, богино болон урт хугацаат түрээсийн гэрээнээс бий болсон эрх үүрэг, төлбөр түргэн гүйцэтгэх чадвартай холбоотой мэдээлэл;

6.6. Компанийн эрх бүхий этгээдээс Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу компанийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан гэж үзэн дахин үнэлгээ хийхээр шийдвэрлэсэн тохиолдолд холбогдох шийдвэр, уг шийдвэрийг гаргах болсон нөхцөл, шаардлага, үнэ цэнэ нь буурсан хөрөнгө болон хөрөнгийн үнэ цэнгийн бууралтын хэмжээ эсхүл хязгаарын тооцоолол;

6.7. Арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийн шалгуурыг хангахгүй болсонтой холбогдуулан бүртгэлийн ангилал бууруулах, эсхүл бүртгэлээс хасагдах мэдэгдэл хүлээн авсан тухай мэдээлэл. Хэрэв үнэт цаас гаргагч нь арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд үлдэх хүсэлт гаргасан бол уг хүсэлт хүргүүлсэн огноо болон дээрх мэдэгдлийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ, бүртгэлтэй хугацаанд биелүүлсэн болон хангаж чадаагүй гэрээгээр хүлээсэн үүргийн талаарх мэдээлэл;

6.8. Компанийн тайланд аудит хийж буй хараат бус нягтлан бодогч ажлаас чөлөөлөгдсөн, халагдсан зэрэг шалтгаанаар өөрчлөгдсөн тохиолдолд энэ талаар мэдэгдэх бөгөөд нягтлан бодогчоос үнэт цаас гаргагчийн дээрх мэдээлэлтэй санал нийлж буй эсэх талаар мэдэгдлийг хавсаргана, эсхүл шинэ хараат бус нягтлан бодогч ажилд орсон бол ажилд томилсон шийдвэр, шинэ нягтлан бодогчийн үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлантай холбоотой гаргасан санал, дүгнэлт, зөвлөгөө;

6.9. Компанийн эрх бүхий этгээдээс компанийн өмнөх жилүүдийн санхүүгийн тайланд алдаа гарсан гэж үзсэн бол алдаатай санхүүгийн тайлангууд, алдаа гарсан гэж үзэх үндэслэл, нөхцөл, компанийн аудитын хороо, эсхүл эрх бүхий албан тушаалтан энэ талаар хараат бус нягтлан бодогчтой хэлэлцсэн эсэх талаар



мэдээлэл, хараат бус нягтлан бодогчоос үнэт цаас гаргагчид санхүүгийн тайлангийн алдаатай байдлын талаар мэдэгдсэн бол нягтлан бодогчоос өгсөн мэдэгдлийн огноо, товч агуулгын талаарх мэдээлэл;

6.10. Компанийн хяналтын багцыг бусад этгээдэд шилжүүлэхтэй холбоотой мэдээлэл: Компанийн хяналтын хувьцааг худалдах болон шилжүүлэхээр хийгдсэн хэлцлийн хугацаа, товч танилцуулга, зорилго, төлбөр төлөх хэлбэр, төлбөрийн зарцуулалт, худалдан авагчийн товч танилцуулга, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт, өмнөх хувьцаа эзэмшигчдийн хувь хэмжээний бууралтын талаарх мэдээлэл;

6.11. Компанийн эрх бүхий албан тушаалтан, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийг томилж, чөлөөлөхтэй холбоотой мэдээлэл, хувьцаа эзэмшигчдийн хурлаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийг томилж, чөлөөлөх, огцруулж, нөхөн томилох, эсвэл томилохоос татгалзсан хурлын тэмдэглэл, шийдвэрийн агуулга, огноо, төлөөлөн удирдах зөвлөлөөс гүйцэтгэх удирдлагыг томилж, чөлөөлсөн талаарх мэдээлэл;

6.12. Компанийн дүрэмд орсон өөрчлөлт: Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж баталсан дүрмийн өөрчлөлтийг Хороо, төрийн холбогдох байгууллагад бүртгүүлсэн огноо, дугаар, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, эцэслэсэн дүрэм;

6.13. Компанийн гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн, гарсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд тухайн ажиллаж байсан компанийн хувьцааг бирж болон биржийн бус зах зээл дээр худалдах, худалдан авахыг хориглосон арга хэмжээ болон үүнтэй холбогдуулан компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс гарсан шийдвэр, арга хэмжээний талаарх мэдээлэл;

6.14. Компанийн ёс зүйн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, зарим хэсгийг түр түдгэлзүүлсэн талаарх мэдээлэл;

6.15. Үйл ажиллагаандаа шинэ техник, технологи нэвтрүүлэх, хувьцааны ханшид нөлөөлөхүйц шинэ бүтээгдэхүүн зах зээлд танилцуулсан, үндсэн болон шинэ бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл, патент, үйл ажиллагаа явуулах болон барааны тэмдэг эзэмших эрх хүчингүй болсон эсхүл цуцлагдсан талаарх;

6.16. Оноосон нэр, үндсэн захиргаа, оршин байх хаяг байршил өөрчлөгдөх, салбар, төлөөлөгчийн газар байгуулах, эсхүл татан буулгах талаарх мэдээлэл;


6.17. Үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдөх, үйл ажиллагаа түр болон удаан хугацаагаар эсхүл бүхэлдээ зогсох;

6.18. Компани төлбөрийн чадваргүй болох, Компанийг татан буулгах чиглэлээр гаргасан шийдвэр;

6.19. Шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

6.20. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга энэхүү журмын 3.1-д заасан мэдээллийг нээлттэй болгох ба гүйцэтгэх удирдлага тухайн мэдээллийн үнэн зөвийг хариуцна.

ДОЛОО. КОМПАНИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ АВАХ



7.1. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь холбогдох хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад баримт бичигтэй танилцах, үнэ төлбөртэйгөөр хуулбарлан авах боломжийг хувьцаа эзэмшигчид олгох үүрэгтэй.

7.2. Компанийн цахим хуудсанд үйл ажиллагааны мэдээлэл болон “Компанийн засаглалын кодекс”-т заасан бодлогын баримт бичгүүд, дотоод дүрэм, журам, зааврыг байршуулж, цаг тухайд нь шинэчлэн хөрөнгө оруулагч, бусад оролцогч талуудыг мэдээллээр хангана.

НАЙМ. МЭДЭЭЛЛИЙГ ХАДГАЛАХ

8.1. Нийтэд мэдээлсэн мэдээллийн баримт бичгийг 5 жилийн хугацаагаар хадгалах ба уг хугацаа дуусмагц архивд шилжүүлнэ.

8.2. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь нийтэд мэдээлсэн мэдээллийн баримт бичгийг хүлээн авах, хадгалах, эрх бүхий этгээдэд танилцуулах, архивд шилжүүлэх ажлыг хариуцаж гүйцэтгэнэ.

ЕС. ДОТООД МЭДЭЭЛЭЛ

9.1. Дотоод мэдээлэл эзэмшигч нь компанийн дотоод мэдээллийг холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасан мэдээллийг нээлттэй болгохоос өмнө санамсаргүй болон санаатайгаар ашиглах, бусдад мэдээлэх, дамжуулах, олж авах нөхцөлийг бүрдүүлэхийг хориглоно.

9.2. Дотоод мэдээллийг цахим хуудас, эсхүл олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, тухайн этгээдэд саадгүй хүргэх боломжийг хангасан бусад хэлбэрээр нийтэд мэдээлж, ил болгоно.

9.3. Компани нь хуурамч, бусдыг төөрөгдүүлсэн мэдээллийг нийтэд мэдээлэхийг хориглоно.

ДОЛОО. БУСАД

10.1. Мэдээллийг нээлттэй болгоход компанийн ТУЗ-өөс хяналт тавина.

10.2. Нээлттэй болгосон мэдээлэлд алдаа, зөрүү гарсан тохиолдолд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь шаардлагатай арга хэмжээг нэн даруй авч залруулна.

10.3. Энэхүү журмын гүйцэтгэлийн үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжихүйц байлгах, сайжруулах зорилгоор ТУЗ нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг эдэлнэ.

-ooOoo-